



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/10

Эрдэнэт

Сумын мэргэн цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын баяр наадмын шагайн харваанд шагналт байранд гурван удаа шалгарсан амжилтыг үндэслэн Батбаярын Балдандоржид сумын мэргэн цол олгосугай.

2.Цолны үнэмлэхийг захирамжийн дугаараар бүртгэсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Амгаланбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАТ-ЭРДЭНЭ